


ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ




Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдлын судалгаанд оролцсон нийт 1630 иргэний 443 нь тулгарсан бэрхшээлээ шийдвэрлэхээр ямар нэг алхам оролдлого хийсэн байна.

Эдгээр иргэдийн 60,7 хувь нь бусдаас ямар нэг туслалцаа аваагүй бөгөөд туслалцаа эрэлхийлсэн 174 иргэний хувьд найз нөхөд, гэр бүл, танил талдаа (34,9%) түлхүү ханджээ.

Тусалцаа авч буй бэрхшээлийн төрөл (хувиар)




Харин ялгаварлан гадуурхалт, хэрэглэгчийн эрхийн зөрчилтэй тулгарах болон төрийн үйлчилгээ авч чадаагүй тохиолдолд бусдаас туслалцаа эрэлхийлдэггүй ажээ. Туслалцаа авсан иргэдийн нийтлэг төрхийг харвал:




Иргэд гэр бүлийн харилцаа, газрын харилцаа үл хөдлөх хөрөнгө, ажил эрхлэлт, мөнгө, цагдаа, хууль сахиулах байгууллагатай холбоотой бэрхшээл тулгарахад мэргэжлийн хуульч, өмгөөлөгчид илүү хандаж байна.

Хуульчаас туслалцаа хүссэн бэрхшээлийн төрөл




Хуульч, өмгөөлөгчөөс туслалцаа авсан хүмүүсийн 48 хувь нь найз нөхөд, ойр дотны хүнээрээ дамжуулж хуульчаа олж авсан бөгөөд тэдний тал хувь нь ямар нэг хөлс төлөөгүй гэж хариулсан байна.

Хуульч, өмгөөлөгчөө олсон эх сурвалж



Бэрхшээл тулгарсан ч туслалцаа эрэлхийлээгүй 267 иргэнээс хэрвээ хуульчаас туслалцаа авсан бол нөхцөл байдал дээрдэх байсан эсэхийг лавлахад 66.8% нь дээрдэхгүй гэж үзжээ. Харин нөхцөл байдал сайжрах байсан гэж үзсэн иргэдийн хувьд дараах байдлаар тус болох байсан гэж үзжээ. Үүнд:



АСУУЛТ

- Энэ дүр зураг бодит байдалтай нийцэж байна уу?
- Иргэдэд шаардлагатай хууль зүйн мэдээлэл, мэргэжлийн хуульчийн туслалцаа авахад нь дэмжлэг болох ямар мэдээллийг нэн тэргүүнд хүргэх вэ?
- Дээрх мэдээллийг ямар сувгаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?